

Гадаад улсын жолооны үнэмлэхтэй хүмүүст

Япон улсад тээврийн хэрэгсэл жолоодох журам

■ Та Япон улсад автомашин жолоодохдоо доорх үнэмлэхний аль нэгийг заавал биедээ авч явах ёстой.

1) Японы жолооны үнэмлэх

2) Замын хөдөлгөөний тухай 1949 оны Женевийн конвенцод үндэслэсэн олон улсын жолооны үнэмлэх

✳ Хэрэв тухайн үнэмлэхийг 1949 оны Замын хөдөлгөөний тухай Женевийн конвенцод нэгдсэн улс олгоогүй, эсхүл конвенцын загварт нийцсэн олон улсын жолооны үнэмлэх биш бол уг үнэмлэхээр Япон улсад тээврийн хэрэгсэл жолоодох боломжгүй.

3) Гадаад улсын жолооны үнэмлэх

Олон улсын жолооны үнэмлэх олгодоггүй боловч жолооны үнэмлэхний тогтолцоо нь Япон улстай дүйцэхүйц түвшний гэж хүлээн зөвшөөрөгдсөн улс орон буюу бүс нутаг (2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар, Швейцарийн Холбоо, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бельгийн Хаант Улс, Монакогийн Гүнт Улс болон Тайвань) олгосон жолооны үнэмлэхийг хүлээн зөвшөөрнө. Ийм тохиолдолд Засгийн газрын тогтоолоор эрх олгогдсон байгууллагаас✳ үйлдсэн япон хэл дээрх орчуулгыг хавсаргасан байх шаардлагатай.

✳ Япон хэл дээр орчуулга хийх эрхтэй, Засгийн газрын тогтоолоор тодорхойлсон дараах этгээдүүд байна.

Үүнд гадаад улсын албан ёсны баталгаат орчуулагч хамаарахгүй.

○ Гадаад улсын жолооны үнэмлэх олгох эрх бүхий захиргааны байгууллага болон тухайн улсаас Японд суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд (Элчин сайдын яам, Консулын газар гэх мэт)

○ Замын хөдөлгөөний тухай хуулийн (жолоодох эрхийн үнэмлэхтэй холбоотой хэсэг) дагуу тухайн улсын жолооны үнэмлэхийг япон хэл рүү орчуулах эрх бүхий байгууллагад дараах этгээдүүд хамаарна: тухайн улсын жолоодох эрхийн үнэмлэх олгох асуудлыг хариуцсан төр захиргааны байгууллагаас Үндэсний Цагдаагийн Газарт мэдэгдсэн, Үндэсний Цагдаагийн Газраас тохиромжтой гэж үзсэн гадаад улсын байгууллага болон бусад этгээдүүд орно (2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн

байдлаар: Тайванийн жолооны үнэмлэхний хувьд Тайвань-Японы харилцааны нийгэмлэг, Германы жолооны үнэмлэхний хувьд Германы автомашины холбоо (ADAC)).

- Гадаад улсын **эрх бүхий удирдлагын байгууллагаас олгосон жолооны үнэмлэхийн япон хэл дээрх орчуулгыг зохих стандартаар үнэн зөв, найдвартайгаар бэлтгэх чадвартай гэж Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын зөвлөлөөс албан ёсоор тогтоосон хуулийн этгээд.

■ Япон улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрх хүчинтэй байх хугацаа

- 1) Японы жолооны үнэмлэх

Хүчинтэй хугацааны дотор

- 2) Олон улсын жолооны үнэмлэх болон гадаад улсын эрх бүхий байгууллагаас олгосон жолооны үнэмлэх

Японд нэвтэрсэн өдрөөс эхлэн 1 жил эсхүл тухайн жолооны үнэмлэхний хүчинтэй хугацаанаас ※1 аль богино хугацаа болох бөгөөд, оршин суугчдын үндсэн бүртгэлд бүртгэлтэй хүн Японоос гарахдаа дахин нэвтрэх зөвшөөрөл авч 3 сараас бага хугацааны дотор буцаж ирсэн тохиолдолд, тухайн буцаж ирсэн өдөр нь олон улсын жолооны үнэмлэхээр жолоо барих хугацааны※2 тооцоонд оруулахгүй.

※1 Олон улсын жолооны үнэмлэх олгогдсон өдрөөсөө эхлэн 1 жилийн хугацаанд хүчинтэй.

※2 Олон улсын жолооны үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн хугацааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт схем зургаас лавлана уу.

Японы жолооны үнэмлэх авах журам

Гадаад улсын эрх бүхий байгууллагын олгосон жолооны үнэмлэхтэй иргэн нь тухайн үнэмлэхийн ангилалд дүйцэх Японы жолооны үнэмлэхийг авахдаа, шалгалтын зарим хэсгээс чөлөөлөгдөх журмаар хүсэлт гаргах эрхтэй.

■ Өргөдөл гаргах газар

Япон дахь оршин суугаа хаягийн харьяа мужийн цагдаагийн газрын жолооны үнэмлэхний төв болон бусад холбогдох салбар нэгжүүд

■ Бүртгүүлэх журам / Шат дамжлага

Таны гаргасан хүсэлтийн дагуу тээврийн хэрэгсэл жолоодох мэдлэг, ур чадварыг тань шалгах бөгөөд жолоодоход ямар нэгэн саадгүй гэж үзсэн тохиолдолд жолооны шалгалтын зарим хэсэг болох онол болон дадлагын шалгалтаас чөлөөлнө.

■ Анхаарах зүйлс

- 1) Гадаад улсын жолооны үнэмлэх авсны дараа тухайн улсдаа нийт 3 сараас доошгүй хугацаагаар оршин суусан байх шаардлагатай (Үүнийг нотлохын тулд хилээр нэвтэрсэн тамга бүхий гадаад паспорт зэрэг оршин суусан хугацааг батлах баримт бичиг хэрэг болно.).
- 2) Төлөөний этгээдээр дамжуулан хүсэлт гаргахыг зөвшөөрөхгүй бөгөөд зөвхөн өөрийн биеэр ирж бүртгүүлнэ.
- 3) Оршин суугчийн үндсэн бүртгэлийн тухай хуульд хамаарахгүй гадаад иргэд нь хуулиар тогтоосон онцгой тохиолдлыг эс тооцвол, ерөнхий журмаар жолооны үнэмлэх авах өргөдөл гаргах боломжгүй.

※ Жолооны үнэмлэх авах хүсэлт гаргах онцгой тохиолдлууд

адаад хэргийн яамнаас олгосон биеийн байцаалт (Дипломат ажилтны үнэмлэх г.м) эсхүл Адилтгах баримт бичгийг Үндэсний цагдаагийн комисс нь гадны хэргийн яамнаас олгосон биеийн байцаалттай тэнцэхээр тогтоосон эрх бүхий байгууллагаас олгосон албан ёсны баримт бичгээр баталгаажуулж чадах иргэн.

Дээрх онцгой тохиолдолд хамаарах этгээд жолооны үнэмлэх авах хүсэлт гаргахдаа тухайн баримт бичгийг үзүүлэхээс гадна нийтийн байгууллагаас олгосон оршин суугаа хаягийг нотлох баримт эсхүл түүнтэй ижил баримтыг бүрдүүлж өгөх шаардлагатай.

Дэлгэрэнгүй мэдээллийг Япон улсын бүс бүрийн Цагдаагийн газрын Жолооны үнэмлэхний төвүүдээс тодруулна уу.

■ Жолооны үнэмлэх мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтууд

- 1) Жолооны үнэмлэх авах мэдүүлгийн хуудас

※ Өргөдөл гаргахдаа эрүүл мэндийн байдлын тухай «Асуумж»-ийг хавсарган өгөх ёстой. Асуумжийн аль нэг заалтад хамаарах тийм гэсэн хариулт өгсөн тохиолдолд хариуцсан ажилтан шинж тэмдгийн талаар нарийвчлан тодруулах болно.

- 2) Өргөдөлд хавсаргах зураг 1 ширхэг

※ Өргөдөл гаргахдаа өмнөх 6 сарын дотор авахуулсан, малгайгүй (шашны болон эрүүл мэндийн шалтгаанаар нүүрний хэлбэр ил харагдахуйц байдлаар

толгойгоо ороосноос бусад), эгц харсан, арын дэвсгэргүй, цээж хэсгээс дээш гарсан зураг байна. Хэмжээ нь 3.0 × 2.4 сантиметр байна. Зургийн ар талд овог нэр болон зураг авахуулсан он, сар, өдрийг бичсэн байх шаардлагатай.

- 3) Төрсөн газрын бүртгэл (гадаад иргэдийн хувьд холбогдох шаардлагатай мэдээлэл) заасан оршин суух гэрчилгээний хуулбар
 - ✳ Шаардлагатай мэдээлэл гэдэг нь оршин суух статус, оршин суух хугацаа гэх мэт, Оршин суугчийн үндсэн бүртгэлийн тухай хуулийн дагуу гадаад иргэний оршин суугчийн бүртгэлд заавал тэмдэглэгдэх мэдээллийг ойлгоно.
- 4) Иргэний бүртгэлийн цахим карт /My Number карт/, гадаад паспорт гэх мэт биеийн байцаалтыг нотлох баримт бичгүүдээс аль нэг төрлийг.
- 5) Гадаад улсын жолооны үнэмлэх (Олон улсын жолооны үнэмлэх хүлээн авахгүй)
- 6) Гадаад улсын жолооны үнэмлэхний япон хэл дээрх баталгаат орчуулга (Үнэмлэх олгосон улсын эрх бүхий байгууллага, Консулын газар, эсхүл хуулиар тогтоосон)✳ байгууллагаас гаргасан байх. Орчуулгад жолоодох тээврийн хэрэгслийн ангилал, хүчинтэй хугацаа болон бусад тусгай нөхцөл зэрэг шаардлагатай мэдээллийг тодорхой тусгасан байна).
 - ✳ Япон хэл дээр орчуулга хийх эрхтэй, Засгийн газрын тогтоолоор тодорхойлсон дараах этгээдүүд байна.

Үүнд гадаад улсын албан ёсны баталгаат орчуулагч хамаарахгүй.

 - Гадаад улсын жолооны үнэмлэх олгох эрх бүхий захиргааны байгууллага болон тухайн улсаас Японд суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд (Элчин сайдын яам, Консулын газар гэх мэт)
 - Замын хөдөлгөөний тухай хуулийн (жолоодох эрхийн үнэмлэхтэй холбоотой хэсэг) дагуу тухайн улсын жолооны үнэмлэхийг япон хэл рүү орчуулах эрх бүхий байгууллагад дараах этгээдүүд хамаарна: тухайн улсын жолоодох эрхийн үнэмлэх олгох асуудлыг хариуцсан төр захиргааны байгууллагаас Үндэсний Цагдаагийн Газарт мэдэгдсэн, Үндэсний Цагдаагийн Газраас тохиромжтой гэж үзсэн гадаад улсын байгууллага болон бусад этгээдүүд орно (2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар: Тайванийн жолооны үнэмлэхний хувьд Тайвань-Японы харилцааны нийгэмлэг, Германы жолооны үнэмлэхний хувьд Германы автомашины холбоо (ADAC)).
 - Гадаад улсын **эрх бүхий удирдлагын байгууллагаас олгосон жолооны үнэмлэхийн япон хэл дээрх орчуулгыг зохих стандартаар үнэн зөв, найдвартайгаар бэлтгэх чадвартай гэж Үндэсний олон нийтийн аюулгүй

байдлын зөвлөлөөс албан ёсоор тогтоосон хуулийн этгээд.

- 7) Тухайн жолооны үнэмлэхийг авснаас хойш тухайн улсад нийт 3 сараас дээш хугацаагаар оршин суусан болохыг нотлох, хил нэвтэрсэн тамга бүхий гадаад паспорт болон үүнтэй адилтгах баримт бичиг.
- 8) Үйлдлийн хураамж

■ Бусад зүйлс


Өвчин эмгэг, хөгжлийн бэрхшээлтэй эсэх талаарх зөвлөгөөг харьяа мужийн Цагдаагийн газрын 'Аюулгүй жолоодлогын зөвлөгөө өгөх нэгж'-ээс авч болно.

Мэдүүлэг хүлээн авах байршил, хүлээн авах цагийн хуваарь, шаардлагатай баримт бичиг, үйлчилгээний хураамж зэрэг нарийвчилсан мэдээллийг харьяа мужийн Цагдаагийн газрын Жолооны үнэмлэхний төвөөс лавлах шаардлагатай.

Япон улсад тээврийн хэрэгсэл жолоодох эрх авах журам

Япон улсын жолооны үнэмлэх авахгүй тохиолдолд

1 Олон улсын жолооны үнэмлэхээр жолоо барих




(Женевийн конвенцод нийцсэн олон улсын жолооны үнэмлэх)

○ Япон улсад нэвтэрсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд 1949 оны Замын хөдөлгөөний тухай Женевийн конвенцод нийцсэн олон улсын жолооны үнэмлэхээр тээврийн хэрэгсэл жолоодож болно. (Замын хөдөлгөөний тухай хуулийн 107 дугаар зүйлийн 2)

※ Женевийн конвенц
1949 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Женев хотноо гарын үсэг зурсан "Замын хөдөлгөөний тухай конвенц"-ыг хэлнэ.

2 Гадаад улсын жолооны үнэмлэхийг япон хэл дээрх орчуулгын хамт ашиглан жолоо барих



(Япон хэл дээрх орчуулга)

(Гадаад улсын жолооны үнэмлэх)

○ Япон улсад нэвтэрсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд, гадаад улсын жолооны үнэмлэхэд япон хэл дээрх орчуулгыг хавсарган биедээ авч явснаар жолоо барих боломжтой. (Замын хөдөлгөөний тухай хуулийн 107 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)

※ Гадаад улс-бүс нутгийн жолооны үнэмлэх Швейцар, Герман, Франц, Бельги, Монако, Тайванийн жолооны үнэмлэх

※ Япон хэл дээрх баталгаат орчуулга Зөвхөн тухайн жолооны үнэмлэхийг олгосон улсын Консулын газар болон Үндэсний олон нийтийн аюулгүй байдлын зөвлөлийн томилсон хуулийн этгээдийн бэлтгэсэн орчуулгыг хүлээн зөвшөөрнө.

Япон улсын жолооны үнэмлэх авах тохиолдолд

1 Жолоодох эрхийн ердийн журмын шалгалтаар үнэмлэх авах (Гадаад улсын жолоодох эрх эзэмшээгүй этгээд)



○ Гадаад улсын жолоодох эрхийн үнэмлэхгүй иргэд жолооны ерөнхий шалгалтад хамрагдаж, Япон улсын жолооны үнэмлэх авах шаардлагатай.

2 Гадаад улсын жолооны үнэмлэхийг шилжүүлэн олгуулах замаар авах (Гадаад улсын жолооны үнэмлэх эзэмшигч)



(Гадаад улсын жолооны үнэмлэх)

○ Автомашин жолоодоход шаардагдах мэдлэг, ур чадварыг эзэмшсэн бөгөөд жолоо барихад саадгүй хүн үнэмлэхээ сольж авах боломжтой.


○ Анхаарах зүйл: Гадаад улсад жолоодох эрх авсны дараа тухайн улсдаа нийт 3 сар буюу түүнээс дээш хугацаагаар оршин суусан байх нь гол нөхцөл болно.

Тусдаа зураг


Олон улсын жолооны үнэмлэх (IDP) ийн хүчинтэй хугацаа

1 Оршин суугчдын үндсэн бүртгэлд бүртгэгдээгүй этгээд Япон Улсад ирсэн тохиолдолд

(1) Олон улсын жолооны үнэмлэх авсны дараа анх удаа Япон Улсад нэвтэрсэн тохиолдолд




(2) Японд анх орж ирсний дараа олон улсын жолооны үнэмлэх авсан тохиолдолд




2 Оршин суугчийн үндсэн бүртгэлд бүртгэгдсэн этгээд Японоос гарч, дахин Японд нэвтэрсэн тохиолдолд

(1) Гадаадад 3 сараас дээш хугацаагаар байж байгаад дахин хилээр нэвтэрсэн тохиолдолд



(2) Гадаадад 3 сараас бага хугацаанд оршин суусны дараа дахин Япон Улсад нэвтэрсэн тохиолдол (Гадаадын иргэдэд түгээмэл тохиолддог)



(3) Гадаадад 3 сараас бага хугацаагаар зорчоод буцаж ирэх тохиолдол (Япон иргэдийн дунд элбэг гардаг жишээ)

